



ОУВС Монгол Улсад хэрэгжүүлж байгаа өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн нэг болон хоёрдугаар шатны үнэлгээг ажлын хэсгийн түвшинд тохиролцлоо

Хэвлэлийн мэдээлэл №17/411

2017 оны 10-р сарын 30

Ажлын хэсгийн айлчлалын төгсгөлд гаргаж байгаа хэвлэлийн мэдээлэл нь ОУВС-гийн мэргэжилтнүүдийн багийн гишүүн оронд ажиллаж гаргасан урьдчилсан үр дүнг танилцуулдаг. Энэхүү мэдээлэлд илэрхийлсэн байр суурь нь ОУВС-гийн мэргэжилтнүүдийн байр суурь бөгөөд тус сангийн Захирлуудын зөвлөлийн байр суурийг заавал илэрхийлэхгүй. Үнэлгээний урьдчилсан үр дүнд үндэслэн ажлын хэсэг тайлан боловсруулж, ОУВС-гийн удирдлагаар батлуулсны дараа Захирлуудын зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэр гаргуулна.

- Гадаад орчин сайжирч, эдийн засагт итгэх итгэл сэргэсний үр дүнд Монгол Улсын эдийн засагт өсөлт бий болж, ДНБ-ний өсөлт энэ онд 3.3 хувь, 2018 онд 4.2 хувьд хүрэх тооцоо гарч байна. Хөтөлбөрийн үндсэн зорилтот үзүүлэлтүүд хангагдлаа.
- Урт хугацааны өсөлтийн үндэс суурийг бүрдүүлж, тэлэлт-агшилтын мөчлөгийг таслан зогсоох бүтцийн шинэчлэлийн чухал ажлууд хийгдэж байна. Эрх баригчдын зүгээс банкны салбарыг бэхжүүлэх, төсвийн бодлогын шийдвэр гаргах тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогуудыг дэмжин ажиллах нь ойрын хугацаанд анхаарлын төвд байх болно.
- Эрх баригчид шинэчлэлийн эрчийн хүчийг алдагдуулалгүй үргэлжлүүлж, урт хугацааны үр өгөөжийг бататгах тууштай байр суурьтай байгааг ОУВС сайшаан дэмжиж байна.

Жэофф Готтлийб-ээр ахлуулсан ОУВС-гийн ажлын хэсэг 10-р сарын 18-наас 30-ны өдрүүдэд Улаанбаатар хотод ажиллаж, 2017 оны 5-р сарын 24-ний өдөр батлагдсан гурван жилийн хугацаатай Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн нэг болон хоёрдугаар шатны үнэлгээний яриа хэлэлцээг хийлээ. Хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 314.5054 сая ЗТЭ буюу ойролцоогоор 434.3 сая ам. долларын зээл олгогдох юм ([Хэвлэлийн мэдээлэл № 17/193-ийг харна уу](#)).

Ажлын хэсгийн айлчлалыг дүгнэж, ноён Готтлийб дараах мэдэгдлийг гаргав. Үүнд:

“Эдийн засаг тооцоолж байснаас өндөр өсөлттэй байна. Нүүрсний экспорт нэмэгдсэн, үйлчилгээний салбар эрчимтэй сэргэж байгаа, ОУВС-гийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх 5.5 тэрбум ам. долларын санхүүжилтийн багц батлагдсаны дараагаар эдийн засагт итгэх итгэл сэргэсэнтэй холбоотойгоор ДНБ-ний өсөлт энэ онд 3.3 хувьд хүрэх төлөвтэй байна. 2018 онд эдийн засаг сэргэн идэвхжиснээр өсөлт илүү өргөн цар хүрээтэй болох боловч нүүрсний салбарын үр дүнгийн үзүүлэлт муудах эрсдэл байна.

“Хөтөлбөрийн хүрээнд тавьсан тоон шалгуур үзүүлэлтүүд бүгд хангагдаж, хэрэгжилт эерэг байлаа. Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэн, зарлага санхүүжилтийг хатуу хяналттай гаргаж байсны үр дүнд төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд тооцоолж байснаас өндөр гарсан. Төсвийн нийт алдагдал 2016 онд ДНБ-ний 17 хувьд хүрч байсан бол энэ онд ДНБ-ний 7.5 хувьтай тэнцүү гарахаар байна. Эрх баригчдын УИХ-д өргөн барьсан 2018 оны төсвийн төсөл нь хөтөлбөрийн хүрээнд тохирсон үзүүлэлт болох ДНБ-ний 6.5 хувиас хэтрэхгүй алдагдалтай байх шалгуурыг хангаж байна. Эрх баригчид төсвийн орлого давж биелсэн тохиолдолд давсан орлогын тал хувиар хуримтлал үүсгэх тууштай байр суурьтай байгаа бөгөөд ингэснээр зээллэг хийх хэрэгцээ шаардлагаа багасган, өрийн тогтвортой байдлыг хангаж ажиллах нөхцөл бүрдэж байна. Давсан орлогын үлдсэн хэсгийг Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтэнд зориулан үр өгөөжтэй, нэг удаагийн арга хэмжээнүүдийг санхүүжүүлнэ. Эрх баригчид нэг удаагийн урамшууллыг төсвийн ажиллагсдад энэ онд болон ирэх онд олгохоор шийдвэрлэсэн. Гадаад валютын цэвэр нөөцийн хэмжээ нэмэгдсэний зэрэгцээ 2017, 2018 онд эргэн төлөгдөх ёстой байсан гадаад бондыг өндөр биш хүүтэйгээр дахин санхүүжүүлж чадсанаар гадаад секторын орчинд тулгарч байсан гол эрсдэл ариллаа.

“Эрх баригчид бүтцийн шинэчлэлийн том зорилтуудаа эхнээс нь хэрэгжүүлээд байна. Бүтцийн шинэчлэлүүд эдийн засгийн өсөлтийг дунд хугацаанд тогтвортой хадгалах, эдийн засгийг төрөлжүүлэх, өрсөлдөх чадварыг дэмжих, тэлэлт-агшилтын мөчлөгийг таслан зогсооход чиглэх юм. Банкны салбарыг эрүүлжүүлэн бэхжүүлэх ажил хийгдэж байна. Нарийвчилсан Активын чанарын үнэлгээний үр дүн энэ оны 12-р сарын дундуур тодорхой болох бол санхүүгийн системийг бэхжүүлэхэд чиглэсэн хууль эрхзүйн шинэчлэлүүдийн төслийг боловсруулж дуусгасан. Мөн түүнчлэн, зохицуулалт, хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох ажил явагдаж байна.

“Төсвийн тал дээр татварын удирдлага, бодлого, төсвийн гүйцэтгэлийн хяналтыг бэхжүүлэх чиглэлээр ахиц дэвшил тогтвортой гарч байна. Энэ хүрээнд төсвийн зөвлөл, татварын бодлогын орчинд үнэлэлт дүгнэлт өгөх үүрэг бүхий дээд хэмжээний ажлын хэсэг байгуулна. Шинэчлэлийн эрч хүчийг 2018 онд бүрэн хадгалж, хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлтийн эдгээр бодлогын урт хугацааны үр өгөөжийг бататгах нь чухал болж байна. Энэ хүрээнд шинээр

байгуулагдсан засгийн газар хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн бодлогыг хэрэгжүүлэхийн төлөө хатуу бөгөөд тууштай байр суурьтай байгаа нь сайшаалтай байна.

“Эрх баригчид ОУВС-гийн ажлын хэсэгтэй өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн нэг болон хоёрдугаар шатны үнэлгээг дүгнэж ажлын хэсгийн түвшинд тохиролцоонд хүрлээ. Энэхүү тохиролцоог ОУВС-гийн Захирлуудын зөвлөл хэлэлцэж баталгаажуулна.

“Ажлын хэсэг Монгол Улсад байх хугацаанд хамтран ажиллаж, бүтээлч хэлэлцүүлэг өрнүүлэн, зочлон хүндэтгэсэн эрх баригчдад талархал дэвшүүлье.”

ОУВС-гийн Мэдээлэл харилцааны газар

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛТЭЙ ХАРИЛЦАХ АЛБА

ХЭВЛЭЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧ: ТИНГ ЯН

УТАС: +1 202 623-7100 **ЦАХИМ ШУУДАН:** MEDIA@IMF.ORG